

Эх барих эмэгтэйчүүдийн эмчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтын жишиг сорил

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
 - 1 ба, 3 дугаар хариултууд зөв бол (B.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (E.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (A.)
 - Зөв, Зөв, Буруу (B.)
 - Зөв, Буруу, Буруу (C.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (E.)

Сонгогдсон сорил

- /1./ Артерийн даралт ихсэх өвчний ямар шатанд дотор эрхтнүүдэд өөрчлөлт гарч эхлэх вэ?
 - A. I үе Б шат
 - B. II үе А шат
 - C. II үе Б шат
 - D. III үе А шат
 - E. III үе Б шат
- /2./ Умайн үйл ажиллагааны цус алдалт нь:
 - A. Эмэгтэйчүүдийн эмгэгийн 10-15%-ийг эзэлнэ
 - B. Ихэвчлэн өнчин тархи-харааны товгор-өндгөвчийн тогтолцооны бүтцийн өөрчлөлттэй холбоотой
 - C. Ихэвчлэн төрөх насны эмэгтэйчүүдэд тохиолдоно
 - D. Ихэвчлэн өсвөр ба цэвэрших насны эмэгтэйчүүдэд тохиолдоно
 - E. Жирэмснээс цус алдах
- /3./ Жирэмсний хожуу хугацаанд ургийн гажиг хөгжлийг найдвартай оношлох аргыг нэрлэ:
 - A. Генетикийн шинжилгээ
 - B. Биохимийн шинжилгээ
 - C. Хэт авиан шинжилгээ
 - D. Гажиг хөгжилтэй ураг төрүүлдэг анамнезтай
 - E. Хэт авиан ургийн шилэн хүзүүний шингэнийг оношлох
- /4./ Халдвар хордлогын дайрлагын үед бөөрний хурц дутагдлыг шээсний гарцаар яаж оношлох вэ?
 - A. 1 цагт 30мл шээс гарч байвал
 - B. 1 цагт 55мл шээс гарч байвал
 - C. 1 цагт 60мл шээс ялгарч байвал
 - D. 1 цагт 100мл шээс гарч байвал
 - E. 1 цагт 80мл шээс гарч байвал
- /5./ Жирэмсний дутуу төрөлт гэсэн нэр томъёоны тухай ойлголт
 - A. Жирэмсний 12 долоо хоног хүртэлх зулбалт
 - B. Жирэмсний 16-18 долоо хоног хүртэлх зулбалт
 - C. Жирэмсний 36 хоногоос хойш төрөх
 - D. Жирэмсний 22-37 хоног хүртэлх төрөлт
 - E. Жирэмсний 39 долоо хоногтой төрөлт

- /6./ Шульцын арга гэж юу вэ?
А. Салсан ихсийг гаргах арга
В. Умайгаас ихэс яаж салсныг мэддэг арга
С. Ихэс салсан эсэхийг шалгадаг арга
D. Төрөхийн өмнө ургийн жинг тодорхойлдог арга
E. Ихэс гаргах арга
- /7./ Тулгар төрөгчийн төрөлтийн 1-р үе үргэлжлэх дундаж хугацааг нэрлэнэ үү:
А. 4-5 цаг
В. 5 - 6 цаг
С. 7 – 8 цаг
D. 10 – 12 цаг
E. 18 – 20 цаг
- /8./ 4000,0-аас дээш том жинтэй хүүхэд төрүүлдэг өгүүлэлтэй жирэмсэн эмэгтэйд глюкоз задлах байдлыг тодруулах сорил хийхэд цусны сахар өлөн үед 120 мг%, 1 цагийн дараа 180 мг% байв.
А. Сорил хэвийн
В. Чихрийн шижин илэрсэн
С. Сорил өөрчлөлттэй
D. Сорилыг давтан хийх
E. Сорил өөрчлөлтгүй
- /9./ Ургийн хөндлөн байрлалын үед дараах эмгэгүүдээс аль нь илүүтэй тохиолдох вэ?
А. Артерийн даралт ихсэх
В. Артерийн даралт багасах
С. Ургийн шингэн эрт, урьтаж гарах
D. Хордлого тохиолдох
E. Ургийн жин нэмэгдэхгүй байх
- /10./ Хэвийн үед Мак-Клюра-Олдричийн сорил хэдэн хором байх вэ?
А. 10 хором
В. 45 хором
С. 1 цаг 30 хором
D. 2 цаг
E. 2 цаг 30 хором
- /11./ Үр хөврөлийн эхийн биетэй холбогдох тэр үйл явцыг юу гэж нэрлэх вэ?
А. Гастроуляци
В. Ихэсжих
С. Имплантаци
D. Эмбриогенез
E. Үр тогтох
- /12./ Жирэмсэн эхийн зүрх судасны тогтолцоонд гарах физиологийн өөрчлөлт
А. Органик өөрчлөлт гарна
В. Зүрхний II цагт диастолын шуугиан илрэнэ
С. Зүрхний оройд сулавтар агшилтын шуугиан 30%-д нь илрэнэ
D. Артерийн даралт 20 мм МУБӨ-өөс ихээр ихсэнэ
E. Зүрхний агшилт 100 удаа болж хурдасна
- /13./ Ихэс түрүүлэлтийг ямар шинжилгээгээр оношийг батлах вэ?
А. Үтрээний үзлэг
В. Рентген шинжилгээ
С. Цистографи
D. Чанд авиан шинжилгээ
E. СТ
- /14./ Жирэмсэн үед эклампси үүсвэл ямар арга хэмжээ авах вэ?
А. Эрчимт эмчилгээний тасагт бүрдмэл эрчимт эмчилгээ хийж хянаана
В. Эрчимт эмчилгээтэй хамт төрөлтийг яаралтай сэдээнэ
С. Умайн хүзүү төрөлтөнд бэлтгэгдсэн бол амниотоми хийнэ
D. Яаралтай кесар хагалгаа хийнэ

- Е. Таталт тавигдсан, эрчимт эмчилгээ хийж байгаа бол цааш хянана
- /15./ Жирэмслэхээс хамгаалахаар хэрэглэдэг гестагены бага тунгийн үйлчлэх механизм нь:
- Өндгөвчийг ажиллуулахгүй
 - Өнчин тархины гонадотропиныг дарангуйлна
 - Үрийн хоолойн хөдөлгөөний идэвхийг алдагдуулна
 - Умайн хүзүүний салсыг шингэрүүлнэ
 - Умайн салстыг хөнгөтүүлнэ
- /16./ Урд хэлбийлт дагзны түрүүлэлтийн үед хөтлөх цэг нь юу вэ?
- Их зулай
 - Бага зулай
 - Дагзны төвгөр
 - Дагзны хонхор
 - Дух
- /17./ Эмнэлэг хүрэх замд төрлөг явагдана гэж үзвэл юу бэлдсэн байх ёстой вэ?
- Саван, гар угаах ус
 - Төрлөгийн нэг удаагийн тусламжийн хэрэгсэл /ир, 3 боолт/
 - Хүүхдийг эх барих, хатаах, өлгийдөх цэвэр даавуу /3/, хүүхдийн цэвэр хувцас.
 - Ихэс хийх пластик хүүдий.
 - Хүүхдэд зориулсан сэхээн амьдруулах амавч, хүүдий.
- /18./ Умайн ерөндөгийг хэрэглэхийг хориглох заалт юу вэ?
- Жирэмсэн
 - Шалтгаан тодорхой бус үтрээний цус алдалт.
 - Үтрээ, умайн хүзүүний үрэвсэл .
 - Умайн хоргүй хавдар.
 - Хүнд хэлбэрийн цус багадалт.
- /19./ Хэвийн жирэмсэн үед ЗСТ –д гарах физиологийн өөрчлөлтийг нэрлэнэ үү:
- Агшилтын даралт нэмэгдэнэ
 - Эргэлдэх цусны хэмжээ нэмэгдэнэ
 - Суларлын даралт нэмэгдэнэ
 - Захын судасны эсэргүүцэл буурна
 - Зүрх бага зэрэг баруун тийш томорно
- /20./ 9 сартай Од хөхөх ба унтаж байхдаа хөлөрдөг, гавлын яс зөөлөрсөн ба булчин сул шинжтэй, салингийн эрхийн шинж илэрсэн. Өөр өвчний шинжгүй .Өрхийн эмчид 50000 нэгжтэй Д валиндэм байхгүй байна. Ээж нь тосон Д аминдэм худалдан авсан байна.Өрхийн эмч хэрхэн ангилаж ямар арга хэмжээ авах вэ?
- Рахиттай гэж ангилна.
 - Нар агаарт гаргаж байхыг зөвлөнө.
 - Тосон Д аминдэмийн уусмалаас (1 дусалдаа 500 нэгжтэй) хоногт 8 дуслаар нэг сар уулгахыг зөвлөнө.
 - Тосон Д аминдэмийн уусмалаас (1 дусалдаа 500 нэгжтэй) хоногт 1 дуслаар нэг жил уулгахыг зөвлөнө.
 - Тосон Д аминдэм (1 дусалдаа 500 нэгжтэй) хоногт 1 дуслаар 6,7,8, 9 саруудаас бусад саруудад уулгахыг зөвлөнө.
- /21./ Жирэмсний эрт үеийн хордлогэмнэл зүйн шинж?
- Огиулж бөөлжих
 - Хоолонд дургүй болох
 - Үнэрлэх, амтлах мэдрэхүй өөрчлөгдөх
 - Даралт ихсэх
 - Хавагнах
- /22./ Манас таталттай эмэгтэйд ямар үед Магнийн сульфатын дараагийн тунг хийхгүй вэ?
- Өвдөгний рефлекс илрэхгүй
 - Шээсний гаралт 4 цагт 100мл-ээс бага
 - Амьсгалын тоо хоромд 16-аас цөөн
 - Таталт үргэлжилсэн хэвээр
 - Толгой өвдөх, дотор муухай оргих, бөөлжих

- /23./ Үйл ажиллагааны оношилгоонд хамаарах шинжилгээг нэрлэнэ үү:
1. Цусанд бэлгийн даавар тодорхойлох
 2. Хүүхэн харааны шинж
 3. Оймын навчны шинж
 4. Кольпоцитологи
 5. Умайгаас хусам авч шинжлэх
- /24./ Төмрийн бэлдмэлийг хэрхэн хэрэглэх талаар ямар зөвлөгөө өгөх вэ?
1. Төмрийн бэлдмэл эрүүл мэндэд хэрэгтэй
 2. Төмрийн бэлдмэлийг хоол идсэний дараа орой бүр ууж байх хэрэгтэй
 3. Баас хар гарвал санаа зовох хэрэггүй
 4. Төмрийн бэлдмэлийг уухад ам хатах шинж илэрвэл шингэн их уух
 5. Төмрийн бэлдмэл харшил эмийг зогсоож болно
- /25./ Өгзөг түрүүлэлтийн үед үүсэж болох хүндрэл:
1. Ургийн шингэн хугацаанаас өмнө гарах
 2. Төрөлтийн үйл ажиллагаа хямрах
 3. Хүй унжих
 4. Толгой гэдийх
 5. Төрсний дараа цус алдах
- /26./ “Завдсан зулбалтын үед эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотیکیг булчинд, судсанд тарина
 2. 4-6 цаг ажиглаад цус алдалт багасахгүй бол эмнэлэгт шилжүүлнэ
 3. Судсаар дусал хийнэ
 4. Цус алдалт намдвал гэрт нь хариулна, 2 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө
 5. Умайд иллэг хийнэ.
- /27./ Ургийн дотоод халдварыг илрүүлэх оношлогооны аргыг нэрлэнэ үү:
1. Эхийн цусанд эмгэг төрөгчийн антиген илрүүлэх
 2. Ургийн шингэнд бичил биетийн ДНК тодорхойлох
 3. Ихсэнд бичил биетийн ДНК тодорхойлох
 4. Хүйн цусанд үрэвслийн эсрэг цитокин тодорхойлох
 5. Хэт авиан шинжилгээ
- /28./ Манас таталтын урьдалтай бол өрхийн эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Ачааллаа багасгахыг зөвлөнө
 2. Долоо хоногийн дараа давтан үзүүлэхийг зөвлөнө
 3. Долоо хоногийн дараа даралт их байвал эмнэлэгт хэвтүүлэхийг сануулна.
 4. Эмнэлэгт хэвтүүлнэ.
 5. Магнийн сульфат хийнэ.
- /29./ Ампициллин, Гентомицин, Метронидазол зэрэг 3 антибиотیکیг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Хэвлийгээр хүчтэй өвдөх эсвэл маш хүнд халууралт өвчнүүд.
 2. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт
 5. Шээсний дээд замын өвчин
- /30./ Эх нярайн бүрдмэл тусламжын хүрээнд төрөх үед юуг бүрдүүлэх шаардлагатай болохыг заана уу?
1. Шаардлагатай цус орлох шингэн, цус сийвэнгээр тасралтгүй хангах,
 2. Нярай хүүхэд болон эхийг дааруулахгүй дулаан байлгах нөхцөлийг бүрдүүлэх
 3. Төрсний дараах үеийн цус алдалтаас сэргийлэх зорилгоор төрөлтийн 3 дугаар үеийг идэвхтэй удирдах,
 4. Төрсний дараах 30 минутын дотор хүүхдэд ангир уургийг нь амлуулж, эхийн өвөрт байлгах нөхцөлийг бүрдүүлэх,
 5. Төрөлтийн явцад нөхөр, хамаатан саданг нь байлцуулах нөхцөлийг бүрдүүлэх
- /31./ Умайн ерөндөгийн үйлчлэх механизмыг тайлбарлана уу?
1. Умайн хөндийд эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг саатуулдаг.

2. Эр бэлгийн эсийг өндгөн эстэй нийлэхээс сэргийлдэг.
 3. Үр тогтоогүй өндгөн эсийг устгадаг.
 4. Эр бэлгийн эсийг үтрээнд оруулдаггүй.
 5. Өндгөн эсийн боловсролтыг удаашруулдаг.
- /32./ Умайн хамааралтай БЮМ дэлийн оношийг баталгаажуулахад аль нь зайлшгүй шаардлагатай вэ?
1. Гонадотропин дааврын түвшинг тогтоох
 2. Прогестероны сорил тавих
 3. Лапароскопи хийх
 4. Гистеросальпингографи СГ
 5. Кломифены сорил
- /33./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийн сул тал юу вэ?
1. Дотор эвгүйрхэх, толгой өвдөх гаж нөлөө илэрч болно
 2. Хөхөөр хөндүүрлэж болно
 3. Биеийн жин бага зэрэг нэмэгдэж болно
 4. Эмийг өдөр бүр уух нь түвэгтэй
 5. Бэлгийн замын халдвараас хамгаалахгүй
- /34./ Төрсөн эхэд ямар шинж илэрвэл яаралтай тусламж хэрэгтэй вэ?
1. Ухаангүй эсвэл татах.
 2. Цус алдаж байгаа эсвэл хэвлийгээр хүчтэй өвдөх.
 3. Толгой өвдсөн эсвэл нүдний харах байдал өөрчлөгдөх.
 4. Маш их бэрхшээлтэй амьсгалах эсвэл халуурах.
 5. Их хэмжээгээр бөөлжих.
- /35./ Ураг орчмын шингэний бүрхүүл жирэмсний 33 долоо хоногоос дээш хугацаанд хагарсан бол ямар тусламж үзүүлэх вэ
1. Тохирох антибиотیکیг тарина
 2. . Антибиотик уулгана.
 3. "Умайн ба ургийн халдвар " гэж ангилаад эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ.
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна.
 5. Ношпа уулгана
- /36./ Жирэмсэн үед яагаад доод мөчдөөр хавагнах хандлагатай болдог вэ?
1. Томорсон умай доод хөндийн венийн судсыг дарснаас
 2. Цусны осмос даралт буурснаас
 3. Доод мөчдийн венийн судасны даралт нэмэгдсэнээс
 4. Биед натри хуримтлагдсанаас
 5. Альдостероны ялгарал нэмэгдсэнээс
- /37./ Бэлгэвч хэрэглэх ашигтай тал юу вэ?
1. Бэлгийн замын халдвараас хамгаална.
 2. Аль ч насны эмэгтэйд тохиромжтой.
 3. Хөхний сүүний гарц, чанарт нөлөөлөхгүй.
 4. Төрөлт, зулбалт, үр хөндөлтийн дараа шууд хэрэглэх боломжтой.
 5. Хүссэн үедээ хэрэглэх, зогсоох боломжтой.
- /38./ Манас таталттай эмэгтэйд диазепамыг хэдийд, яаж хэрэглэх вэ?
1. Магнийн сульфатын давтан тунг авсаны дараа таталт үргэлжилсэн хэвээр бол
 2. Магнийн сульфатын хордлого илэрсэн бол
 3. Магнийн сульфат байхгүй бол
 4. Диазепамыг цохилтын тунгаар 10 мг-аар судсанд аажим тарина
 5. Диазепамыг барих тунгаар 40 мг-ыг 500 мл Рингер Лактатын уусмалд найруулж 6-8 цаг дусаана.
- /39./ Арын хүнхрээгээр хатгалт хийх заалтыг нэрлэнэ үү
1. Умайн гаднах жирэмсэн
 2. Өндгөвчийн идээт үрэвсэл
 3. Пельвиоперитонит
 4. Перитонит

5. Умайн хоргүй хавдар
- /40./ Эрт үеийн бөөлжилтийн эмчилгээг нэрлэнэ үү:
1. Хоолны дэглэм
 2. Шингэн сэлбэх
 3. Тайвшруулах бэлдмэл
 4. Зүү тавих
 5. Амин дэм
- /41./ Тээвэрлэх болон гэрийн төрөлтийн үеийн яаралтай тусламжинд ямар эмүүд зайлшгүй шаардлагатай вэ?
1. Окситоцин, эргометрин
 2. Магнийн сульфат, диазепам
 3. Кальцийн глюконат
 4. Ампициллин, Гентамицин, Метронидазол
 5. Рингенийн лактат
- /42./ Ампициллин, Гентомицин зэрэг 2 антибиотیکیг эмэгтэйд ямар заалтаар зэрэг хэрэглэдэг вэ?
1. Маш хүнд халууралт өвчнүүд
 2. Шээсний дээд замын өвчин эсвэл уушгины хатгаа
 3. Умайн болон ургийн халдвар
 4. Төрсний дараах цус алдалт
 5. Хүндрэлтэй зулбалт, үр хөндөлт.
- /43./ ЭМС –ын 39 тоот тушаалын жирэмсэн эмэгтэйд эмнэлгийн тусламж үзүүлэх журамын хүрээнд өрх сумын эмчийн хийх ажилыг нэрлэнэ үү
1. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн бүртгэл гаргана
 2. Төмөр, фолийн хүчлийн бэлдмэлээр болон бусад урьдчилан сэргийлэх эмчилгээг хийж, жирэмсэн үеийн дасгалд бүрэн хамруулна.
 3. Эсэн мэнд амаржихуйн үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх
 4. Эмэгтэйчүүдэд эрүүл мэндийн үзлэг хийж, эрүүл мэндийн бүлгээр ангилан. эмчлэн эрүүлжүүлнэ
 5. Жирэмснийг эрт илрүүлэн жирэмснийг тээлгэх эсэх болон оношилгоо эмчилгээний асуудлыг нь шийдвэрлэнэ
- /44./ Жирэмсэн үед бэлэг эрхтэнд дараах физиологийн өөрчлөлтүүд илэрнэ:
1. Үтрээний салст хөхөлбөр болно;
 2. Бэлгийн уруулын тосны булчирхай шүүрэл ялгарал ихсэнэ
 3. ГБЭ хөөнгөтнө
 4. Хэлүү томорно
 5. Хярзан төмбийнө
- /45./ Пролактин даавар хаана боловсорч ялгарах вэ?
- A. Өндгөвчинд
 - B. Умайд
 - C. Өнчин тархинд
 - D. Хөхний булчирхай
 - E. Харааны товгор
- /46./ Клементсийн сорилоор юуг тодорхойлж болохыг хэлнэ үү.
- A. Ургийн жинг урьдчилан тогтооно
 - B. Изо-серологийн үл зохицолдоог тодруулна
 - C. Ургийн бүтэлтийг илрүүлнэ
 - D. Ургийн уушигны хөгжлийн гүйцлийг тодорхойлно
 - E. Ургийн хөдөлгөөний идэвхжилийг тодорхойлно
- /47./ Төрсний дараах үе гэдэг нь:
- A. Төрсний дараах эхний 24 цаг
 - B. Төрснөөс хойш 4 долоо хоног
 - C. Төрснөөс хойш 8 долоо хоног

- D. Төрсний дараа эхний 2 цагаас 4 долоо хоног хүртэл
E. Төрснөөс хойш 72 хоног
- /48./ Эх барих эмэгтэйчүүдийн судлалд хэт авиан шинжилгээний давуу чанар
A. Ямар ч нөхцөлд шинжилж болно
B. Мэдээллийг тэр дор нь өгдөг
C. Эх урагт аюул эрсдэл байхгүй
D. Давтан хийж болно
E. Бүгд хамааралтай
- /49./ Жирэмснээс хамгаалах дан прогестерон агуулсан эмийг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?
A. Биений юм ирсэн 3 дах өдөр.
B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина.
D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.
E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.
- /50./ Ямар үед зүрхний өвчтэй эмэгтэйд гликозид хэрэглэх вэ?
A. I хоромд зүрхний агшилт 70, амьсгал 18 удаа байхад
B. I хоромд зүрхний агшилт 115, амьсгал 24-өөс дээш болвол
C. Зүрхний агшилт 88, амьсгал 20 болбол
D. Зүрхний агшилт 70, амьсгал 30 болбол
E. Зүрхний агшилт 80, амьсгал 18 болбол
- /51./ Умайн үйл ажиллагааны цус алдалт үүсэх нөхцөл нь:
A. Бэлгийн дааврын хэмжээ ер бусын байдлаар өөрчлөгдөх
B. Бэлгийн даавар ялгарах динамик явц алдагдах
C. Умайн салстын бүтцийн өөрчлөлт
D. Умайг салстын цусан хангамжийн хямрал
E. Умайг салстын үрэвсэл
- /52./ Ургийн хүзүүг хүй ороосныг оношлох сорил:
A. Окситоцины сорил
B. Фонокардиографийн шинжилгээ
C. Чанд авиан Гонын сорил*
D. Хүчил-шүлтийн суурийн өөрчлөлтөөр
E. Эхийн ургийг рентгенээр шинжлэх
- /53./ Нийт цусны артери, вени, зүрхний хөндий, капиллярт хувиарлагдах зөв харьцааг заах
A. 50 % вени, 30 % артери, 12 % капилляр, 3 % зүрхний хөндий
B. 30 % вени, 50 % артери, 25 % капилляр, 3 % зүрхний хөндий
C. 70 % вени, 15 % артери, 12 % капилляр, 3 % зүрхний хөндий
D. 10 % вени, 30 % артери, 8 % капилляр, 2 % зүрхний хөндий
E. 40 % вени, 30 % артери, 20 % капилляр, 10 % зүрхний хөндий
- /54./ Жирэмсний илүү тээлтийн үед эх барих үзлэгээр илрэх онцлог шинж тэмдэг
A. Ургийнхөдөлгөөн ихсэх
B. Ургийн хөдөлгөөн багасах
C. Ургийн зүрхний цохилт хэвийн байх
D. Хэвлийн эргэн тойрон нэмэгдэхгүй байх
E. Хэвлийн эргэн тойрон ихсэх
- /55./ Дунканы арга гэж юу вэ?
A. Салсан ихсийг гаргах арга
B. Умайгаас ихэс яаж салсныг мэддэг арга
C. Ихэс салсан эсэхийг шалгадаг арга
D. Төрөхийн өмнө ургийн жинг тодорхойлдог арга
E. Ихэс гаргах арга
- /56./ Төрөлтийн 1- р үе хэзээ төгсдөг болохыг тэмдэглэнэ үү:
A. Ургийн шингэн гарснаар
B. Дүлэлт эхэлснээр
C. Умайн хүзүү 8 см нээгдснээр

- D. Умайн хүзүү бүрэн нээгдсэнээр
E. Хүүхэд төрснөөр
- /57./ Жирэмсний төгсгөлд тарган эмэгтэйн биеийн жингийн нэмэгдэлт ямар байх вэ?
A. Тарган биш эмэгтэйнхтэй адилхан жин нэмэгдэнэ /10 мг орчим/
B. Биеийн жин 10-15 кг-аар нэмэгдэнэ
C. Биеийн жин хэт ихсэнэ /15-аар их/
D. Хэвийн жинтэй эмэгтэйнхээс харьцангуй бага нэмэгдэнэ /6-7 кг/
E. Жирэмсний явцад жин огт нэмэгдэхгүй
- /58./ Ургийн толгой их ташуу хэмжээг заана уу?
A. 9,5
B. 11
C. 13.5
D. 12
E. 10.5
- /59./ Төрөх үеийн хэвийн цус алдалтын эрүүл, эмгэгийн зааг ямар хэмжээтэй байдаг вэ?
A. 800
B. 100
C. 150-300
D. 400
E. 500
- /60./ Аль нь ургийн гадаад орчин болдог вэ?
A. Хорион
B. Умай
C. Шар уутанцар
D. Аллантаис
E. Амнион
- /61./ Жирэмсэн бус төрөөгүй үед умайн хэвийн хэмжээ?
A. 20 гр
B. 30 гр
C. 50 гр
D. 70 гр
E. 80 гр
- /62./ Леопольдийн 1-р аргаар юуг тодорхойлох вэ?
A. Умайн ёроолын өндрийн түвшин
B. Ургийн байрлал
C. Түрүүлсэн хэсэг
D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
E. Ургийн жин
- /63./ Ихэс түрүүлэлтийн үед илрэх эмнэл зүйн гол шинжийг нэрлэнэ үү:
A. Умай чангарч, хоёр тал жигд биш, эмзэглэлтэй
B. Удаан хугацаагаар их хэмжээтэй цус алдах
C. УЗЦ байхгүй болох
D. Умай чангаралгүй, улаан ягаан цус гарах
E. Дотор муухай оргиж бөөлжих
- /64./ 35-40 насны эмэгтэйчүүд жирэмсэлтээс хамгаалах эм хэрэглэхийг ямар үед эрс хориглох вэ?
A. Тромбо-эмболийн өвчнүүдтэй бол
B. Хөхүүл байх үед
C. Хэрлэгийн идэвхжилтэй бол
D. Таргалалттай бол
E. Биений юмны хямралтай бол
- /65./ Үтрээний хэвийн орчин нь:
A. pH 4-5
B. pH 6-7
C. pH 7-8

D. рН 9-10

E. рН 1-2

/66./ Умайн жигд биш агшилтийн үед ямар эмчилгээг хийх вэ?

A. Өвчин намдаах, агчилт тавиулах эмчилгээ

B. Төрөх хүчийг дэмжих

C. Хүлээн ажиглах

D. Төрөлтийг яаралтай кесар хагалгаагаар явуулна

E. Сулрал гэж үзэж сэдэх эмчилгээ хийнэ

/67./ Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхролтыг оношилох мэдээлэл сайтай арга аль нь вэ?

A. Эх барихын гадуур үзлэг

B. Үтрээний үзлэг

C. Хэт авиан оношилгоо

D. Ургийн зүрхний үйл ажиллагааг үнэлэх

E. Цусны бүлэгнэлтийг тодорхойлох

/68./ Овуляци гэдэг ойлголтын зөв тодорхойлолтыг дурдана уу?

A. Шар бие өсөж боловсрох

B. Фолликулд өндгөн эс боловсрох

C. Боловсорч, бие гүйцсэн фолликул хагарах

D. Фолликул өсөж, хөгжиж боловсрох

E. Сарын тэмдэг ирэхэд нөлөөлөх

/69./ Жирэмснээс хамгаалах депо-провераг хэдийд хэрэглэх нь тохиромжтой вэ?

A. Биений юм ирсэн 3 дахь өдөр.

B. Биений юм ирсэн 5 дахь өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.

C. 12 долоо хоног буюу 3 сар тутам нэг удаа булчинд тарина.

D. Биений юм ирсэн эхний өдрөөс эхлэн өдөр бүр нэг шахмалыг ууна.

E. Бэлгийн хавьталд орохын өмнө тогтмол.

/70./ Жирэмсэн 29 настай, бага зэрэг халуурна, цусанд цагаан бөөмний тоо ялимгүй олширсон, СОЭ түргэссэн, АСЛО, С реактив уураг идэвхжилтэй бол хэрлэгийн идэвхжилийн хэддүгээр зэрэгт хамаарах вэ?

A. А I зэрэг

B. А II зэрэг

C. А III зэрэг

D. Б I зэрэг

E. Б II зэрэг

/71./ Эмэгтэй Д. 30 настай. Эмэгтэйчүүдийн өвчнөөр өвдөж байгаагүй. Харин саяхан биений юмны 20 дахь хоногоос умайгаас цус алдсаны учир үзүүлэв. Ямар шинжилгээг эхэлж хийх вэ?

A. Үтрээний эсийн шинжилгээ

B. Умайн салстын эдийн шинжилгээ

C. Умайн хөндийн зураг авах

D. Умайн хүзүүний салстыг дурандах

E. Умайн хөндийг сэтгүүрдэх

/72./ Дараах аргуудаас алийг оношлогооны бүх тохиолдолд хэрэглэдэг вэ?

A. Генеологийн

B. Цитогенетикийн

C. Биохимийн

D. Эс судлалын

E. Иммуногенетикийн

/73./ 1800гр жинтэй төрсөн нярайг хэддүгээр зэргийн дутуу гэж үзэх вэ?

A. I зэрэг

B. II зэрэг

C. III зэрэг

D. IV зэрэг

E. V зэрэг

- /74./ Жирэмсний эрт хугацааг хэт авиан шинжилгээний юуг үндэслэн тогтоох вэ?
- A. Ургийн зүрхний цохилтоор
 - B. Ургийн хөдөлгөөнөөр
 - C. Ургийн зулай-ахар сүүлний уртаар
 - D. Ургийн толгойн их хөндлөн хэмжээгээр
 - E. Ургийн чөмөгт ясны уртаар
- /75./ Ургийн толгой бага аарцгийн орох амсрын дээр байхад Леопольдын IV байрлалаар ямар байх вэ?
- A. Ургийн толгойн оройгоор эмчийн гарын хуруу орохгүй боловч толгой аарцгийн дээр тэмтрэгдэнэ
 - B. Ургийн толгойн оройгоор эмчийн гарын хуруу хоёр талаасаа нийлнэ
 - C. Толгой тэмтрэгдэхгүй
 - D. Бага аарцгийн орох аарцгийн дээр ургийн толгойн багахан
 - E. Ургийн толгой хөдөлгөөнтэй байна
- /76./ Ураг орчмын шингэн урьтаж гарах гэдэг нь:
- A. Төрөлтийн үйл ажиллагаа эхэлсний дараа
 - B. Төрөлтийн үйл ажиллагаа эхлээгүй байхад
 - C. Умайн хүзүү 4-5 см нээгдсэн үед
 - D. Умайн хүзүү 5-6 см нээгдсэн үед
 - E. Умайн хүзүү бүрэн нээгдэхээс өмнө
- /77./ Жирэмсний хурц өөхөн гепатозын үед СЦТБ хам шинжийн ямар өөрчлөлт гарах вэ?
- A. Өөрчлөгдөхгүй
 - B. Төмөр дутагдлын цус багадалт болно
 - C. Энэ шинж тэмдэг тод илэрнэ
 - D. Артерийн даралт гэнэт ихсэнэ
 - E. Артерийн даралт буурна
- /78./ Ургийн үе жирэмсний аль хугацаанаас эхэлдэг болохыг нэрлэнэ үү?
- A. Эхний нэг сарын төгсгөл
 - B. Хоёрдох сард
 - C. Гурав дахь сарын эхээр
 - D. Гурав дахь гурван сарын төгсгөлөөр
 - E. Дөрвөн сарын эхээр
- /79./ Жирэмсэн бус үед умайн хөндийн урт /см/
- A. 2-3 см
 - B. 3-4 см
 - C. 4-5 см
 - D. 6-7 см
 - E. 12-13 см
- /80./ Леопольдийн 2-р аргаар юуг тодорхойлох вэ?
- A. Умайн ёроолын өндрийн түвшин
 - B. Ургийн байрлал, хэлбийлт
 - C. Түрүүлсэн хэсэг
 - D. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгтэй харьцах байдал
 - E. Ургийн жин
- /81./ Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхрох үед илрэх онцлог шинжийг нэрлэнэ үү:
- A. Умай чангарч, тэмтэрхэд эмзэглэлтэй болно
 - B. Ургийн байдалд өөрчлөлт илрэхгүй
 - C. Амьсгал авахад төвөгтэй амьсгаадна
 - D. Ургийн буруу байрлал үүснэ
 - E. АД ихдэнэ
- /82./ Умайн ба ургийн халдвар ” үүссэн эмэгтэйд ямар тусламж үзүүлэх вэ?
1. Тохирох антибиотикийг тарина
 2. Антибиотик уулгана
 3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
 4. Төрөх үйл ажиллагаа эхэлсэн эмэгтэйтэй адил арга хэмжээ авна.

5. Ношпа уулгана

/83./ Өвөр янзтай дагз түрүүлсэн төрлөгийн үед ургийн толгойд хэдэн тулах цэгтэй байдаг вэ?

- A. Нэг
- B. Хоёр
- C. Гурав
- D. Дөрөв
- E. Тулах цэг үүсэхгүй

/84./ Жирэмсэнг эрт оношилоход хамаарахыг нэрлэнэ үү:

- 1. Хошногоны халуунаар
- 2. ХГД шээсэнд тодорхойлох
- 3. ЭХО
- 4. Хяналтаар
- 5. Ажиглалтаар

Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)

- 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (A.)
- 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (B.)
- 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (C.)
- Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
- Бүх хариулт зөв бол (E.)

/85./ Эхээс хүүхдэд ХДХВ-ийн халдвар дамжих магадлал хэдийд хамгийн өндөр байдаг вэ?

- A. Хүүхэд эхийн хэвлийд байх үед
- B. Хөхүүл үед
- C. Нярай үед
- D. Төрөх үед
- E. 1-5 насанд

/86./ Хожуу гестозын хүнд хэлбэрийн үед ямар зорилгоор эх барихын хавчуур тавих вэ?

- A. Цус алдалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор
- B. Дүлүүлэхгүй байхын тулд
- C. Нярайг бүтэлтээс хамгаалахаар
- D. Умай урагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор
- E. Базалтаас чөлөөлөх зорилгоор

/87./ Хэт авианы шинжилгээнд “цасны хуйлирааны” шинж ямар эмгэгийн үед илэрдэг вэ?

- A. Ураг амьгүй болох
- B. Цулцан хураа
- C. Өсөлтгүй жирэмсэн
- D. Хорионэнцителиом
- E. Ураг орчмын шингэн ихдэлт

/88./ Умайн салстын хэт зузаарлыг найвдартай оношилох аргыг нэрлэнэ үү

- A. Эхо
- B. Умайг дурандах
- C. Умайн хөндийгөөс эсийн шинжилгээ авах
- D. Гистеросальфингографи
- E. Умайн салстыг хусаж гистологи шинжилгээ хийх

/89./ Төрөх өрөөнд хянагдаж байгаа эмэгтэйд гэнэт бөөлжих, хэвлийгээр хүчтэй өвдөх, арьс салст цайх шинжүүд илэрч артерийн даралт буурсан. Умайн хүзүү умайн см 6 нээлттэй, толгой 2/5-аар тавигдсан. Ургийн зүрхний цохилт удааширч цөөрсөн бол ямар хүндрэл тохиолдсон байж болох вэ?

- A. Төрөх хүчний сулрал
- B. Умайн хэт эрчимтэй базлалт
- C. Ихсийн бүрэн түрүүлэлт
- D. Ихэс ховхролт

- Е. Эмнэл зүйн уйтан аарцаг
- /90./ Үтрээний үзлэгээр төрөлтийн үед ургийн толгой суудал ясны түвшинд байсан бол яаж тавигдсан байна гэж үзэх вэ?
- A. +2
 - B. +1
 - C. 0
 - D. -1
 - E. -2
- /91./ Цэвэршилтийн дараа дааврын түвшин яаж өөрчлөгддөг вэ?
- A. Өөрчлөлт бага илэрнэ
 - B. ФСГ болон ЛГ буурна
 - C. ФСГ болон ЛГ нэмэгдэнэ
 - D. Пролактин нэмэгдэнэ
 - E. Прогестероны түвшин нэмэгдэнэ
- /92./ Чихрийн шижин өвчний үед ураг томрох, эд эсийн дутмагшил үүсэхэд юу нөлөөлөх вэ?
- A. Инсулин
 - B. Глюкоз
 - C. Нүүрс ус
 - D. Зөв хооллолт
 - E. Хоол сойх
- /93./ Бэлгийн хөгжил эрт эхлэх эмгэгт хамааралгүйг нэрлэнэ үү
- A. Бэлгийн 2 догч шинж 8 наснаас эхэлнэ
 - B. Охидод эрт хугацаанд ясны өөслтийн зон хаагдана
 - C. Төрөлхийн бөөрний дээд булчирхайн зузааралтай байх нь элбэг
 - D. Цусанд ДГЭАС, ДГАС толорхойлж оношилно
 - E. Эстрген прогестероны хасарсан бэлдмэлээр эмчилнэ
- /94./ Умайн гаднах жирэмслэлтийг эрт хугацаанд ялган оношлохын тулд ХГД-ыг цусанд хэдийн хугацааны дараа давтан тодорхойлох шаардлагатай вэ?
- A. 12-24 цагийн дараа
 - B. 24-36 цагийн дараа
 - C. 48-72 цагийн дараа
 - D. 72-108 цагийн дараа
 - E. 7 хоногийн дараа
- /95./ Дараах тохиолдлын алинд нь АФП ургийн шингэнд хэвийн байх вэ?
- A. Нугасны эмгэг
 - B. Тархигүй ураг
 - C. Улаан хоолойн битүүрэл
 - D. Резүс үл тохирно
 - E. Илүү тээлт
- /96./ Эмэгтэй 1000 гр жинтэй хүүхэд төрүүлсэн, нярай 2 хоноод нас барсан бол ямар эндэгдэлд хамаарах вэ?
- A. Антенаталь
 - B. Пренаталь
 - C. Интранаталь
 - D. Неонаталь
 - E. Перинаталь
- /97./ Хүнд хэлбэрийн цус багадалттай жирэмсэнд хэдэн мг төмрийн бэлдмэл уулгах вэ?
- A. 50-60 мг
 - B. 60-80 мг
 - C. 100-120 мг
 - D. 150-300 мг
 - E. 400 мг
- /98./ Биений юм ирэхийн өмнөх хам шинжийн үндсэн эмчилгээг дурьдана уу?
- A. Даавар эмчилгээ
 - B. Мэдрэл-сэтгэцийг тайвшруулах эмчилгээ

- С. Дархлал заслын эмчилгээ
D. Антибиотек эмчилгээ
E. Өндгөвчийг хэсэгчлэн авах мэс заслын эмчилгээ
- /99./ Прولاктин даавар хаана боловсорч ялгарах вэ?
A. Өндгөвчинд
B. Умайд
C. Өнчин тархинд
D. Хөхний булчирхай
E. Харааны товгор
- /100./ Ганглио-хориг үйлчилгээтэй эмийн хэрэглэж болохгүй заалт:
A. Ургийн бүтэлт
B. Артерийн даралт ихдэх өвчин
C. Тархины хавагнах
D. Артерийн даралт ихссэн криз өгөх
E. Бөөрний эмгэгээс үүдэлтэй даралт ихсэх
- /101./ Эх урагын хооронд резүс үл тохироо үүсэх нөхцлийг нэрлэнэ үү
A. Эх нь Rh -, эцэг нь Rh +, хүүхэд Rh -
B. Эх нь Rh +, эцэг нь Rh -, хүүхэд Rh +
C. Эх нь Rh -, эцэг нь Rh -, хүүхэд Rh -
D. Эх нь Rh -, эцэг нь Rh +, хүүхэд Rh +
E. Эх нь Rh +, эцэг нь Rh -, хүүхэд Rh -
- /102./ Төрөлтийн явцад ургийн шингэн гарахдаа зунгагаар будагдсан байвал ямар арга хэмжээ авах вэ?
A. Яаралтай кесар хагалгаа хийнэ
B. Хүн судаснаас хийн солилцоог шинэилнэ
C. Амниоинфүзи хийнэ
D. Ургийн толгойн хухйнаас цус авч шинжилнэ
E. Байнга ургийн монитор хяналтанд байлгана
- /103./ Жирэмсний илүү тээлтийн үед эх барих үзлэгээр илрэх онцлог шинж тэмдэг
A. Ургийн хөдөлгөөн ихсэх
B. Ургийн хөдөлгөөн багасах
C. Ургийн зүрхний цохил төөрчлөгдөх
D. Хэвлийн эргэн тойрон нэмэгдэхгүй байх
E. Умайн ёроол өндөршинэ
- /104./ А. 52 настай, сүүлийн 3 сар доошоо үе үе цусархаг зүйл гарна, биений юм сүүлийн үед тогтворгүй болсон сүүлийн долоо хоногт хэмжээ нь ихсээд байна гэсэн зовиуртай эмэгтэйчүүдийн эмчид иржээ.
Эмэгтэйд эхлээд хийгдэх шинжилгээг нэрлэнэ үү
A. Цусанд СА-125 тодорхойлно
B. Умайн хөндийг хусаж эдийн шинжилгээ авна
C. MRI шинжилгээ хийлгэнэ
D. Умайг дурандана
E. Даавар цус тогтоолт хийнэ
- /105./ БЮМ 28 хоногийн зайтай ирэх бүртээ 200 мл орчим цус гарч байвал юу гэж нэрлэх вэ?
A. Метрорагия
B. Полименорея
C. Гиперменорея
D. Опсоменорея
E. Дисменорея
- /106./ Жирэмсний 23 долоо хоногтой эхийн шээсний шинжилгээнд: сахар (+), бусад үзүүлэлтүүд хэвийн бол шалтгааныг тайлбарлана уу
A. Эмэгтэй шижинтэй байсан
B. Эмэгтэй шээсний замын халдвартай байсан
C. Шээсэнд хэвийн үед заримдаа сахар илэрч болно

D. Жирэмсэн үеийн физиологи өөрчлөлттэй холбоотой

E. Эмэгтэйд бөөрний эмгэг байсан

/107./ Жирэмслэхээс хамгаалах умайн ерөндөг хэрэглэхэд анхаарах зүйл нь:

A. Биений юм ирээд дуусах үед умайд тавина

B. Заавал стационарын нөхцөлд тавина

C. Зуршсан байдлаар үр зулбадаг үед хэрэглэж болохгүй

D. Цусны даралт ихдэх өвчтэй эмэгтэйчүүдэд хэрэглэхийг хориглоно

E. Өмнө нь кесар мэс заслаар төрсөн бол тавих боломжгүй

/108./ Эндометриозын эмнэл зүйд альнаас бусаад нь илрэх вэ?

A. БЮМ өвдөлттэй ирэх

B. Үтрээний ялгарал ихсэх

C. Бэлгийн хавьтлын үед өвдөх

D. Үргүйдэл

E. Наалдац

/109./ Умайн гаднах жирэмслэлтийг эрт хугацаанд ялган оношлохын тулд ХГД –ыг цусанд хэдий хугацааны дараа давтан тодорхойлох шаардлагатай вэ?

A. 12-24 цагийн дараа

B. 24-36 цагийн дараа

C. 48-72 цагийн дараа

D. 72-108 цагийн дараа

E. 7 хоногийн дараа

/110./ Жирэмсний эрт хугацаанд аяндаа зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:

A. Цусны бүлгийн үл тохироо

B. Хүнд юм өргөх

C. Умайд соривтой байх

D. Хромосомын эмгэг

E. Умайн хүзүүний дутмагшил

/111./ Арын янзтай дагз түрүүлсэн төрлөгийн үед ургийн толгойн төрөх ххэмжээг нэрлэнэ үү?

A. Их ташуу хэмжээ

B. Дунд ташуу хэмжээ

C. Бага ташуу хэмжээ

D. Шулуун хэмжээ

E. Босоо хэмжээ

/112./ БЮМ-ийн аль үед прогестерон даавар хамгийн их ялгарах вэ?

A. Ургийн цэврүү боловсорч эхлэх үед

B. Ургийн цэврүү боловсорч гүйцэх үед

C. Эм бэлгийн эс гадагшилсны дараа

D. Эм бэлгийн эс боловсрох үед

E. Мөчлөгийн 22-26 дахь хоногт

/113./ Мизопростол нь ямар төрлийн бэлдмэл вэ?

A. Синтетик окситоцин

B. Простогландин F2

C. Простогландин E1

D. Простогландин E2

E. Ru-486 pill

/114./ Ихэр ураг төрөх үед дараах тохиолдлуудын аль нь илүү эрсдэлтэй болохыг нэрлэнэ үү:

A. Хоёр ураг хоёулаа толгойгоороо түрүүлсэн бол

B. Эхний ураг өгзөг, дөрөөгийн ураг толгой түрүүлэлт

C. Хоёр ургийн урьдчилсан жин 6 кг

D. Дихориан болон диамнион бүрхүүлтэй

E. Ургийн шингэн цагаас урьтаж гарсан

/115./ Биений юмны хэвийн мөчлөгийн үед өндгөн эс гадагшлах үндсэн нөхцөл нь:

A. Эстрогены даавар хамгийн их хэмжээнд хүрэх

- В. ФСД - хамгийн их хэмжээндээ хүрэх
- С. Сөрөг эргэх урвалаар ФСД буурах
- Д. Эерэг эргэх урвалаас ЛД ихсэх
- Е. Поргестерон даавар хамгийн их хэмжээнд хүрэх

/116./ Кефалогематом гэдэг нь

- А. Зөөлөн эдийн хаван
- В. Ясан доор цус хурах
- С. Арьс өөхөн эдийн завсар цус хурах
- Д. Тархины хатуу хальсны доор цус хурах
- Е. Тархины ховдолд цус хурах

/117./ А. 52 настай, сүүлийн 3 сар доошоо үе үе цусархаг зүйл гарна, биений юм сүүлийн үед тогтворгүй болсон сүүлийн долоо хоногт хэмжээ нь ихсээд байна гэсэн зовиуртай эмэгтэйчүүдийн эмчид иржээ.

Умайн салстын хучуурууд олон янзын хэлбэршилтэй болсон, бөөм нь хромоор хэт будагдсан, эсийн хуваагдал эрчимтэй явагдсан бол ямар эмгэг өөрчлөлт байж болох вэ?

- А. Умайн хоргүй хавдар
- В. Умайн салстын булчирхайлаг зузаарал
- С. Умайн салстын өмөнгийн урьдал
- Д. Умайн салстын өмөн
- Е. Умайн салстын үрэвсэл

/118./ Өсөлтгүй жирэмсэн үед дараах хүндрэлээс аль нь тохиолдох эрсдэлтэй вэ

- А. Коагулопати
- В. Зуршсан зулбалт
- С. Үжил халдвар
- Д. Үргүйдэл
- Е. Дараагийн жирэмслэлтэнд гаж хөгжил үүсэх

/119./ Тулгар төрөгчийн умайн хүзүү 8-9 см нээгдсэн байна, Цаашдаа ургийн толгой ямар хурдтай доошлох вэ?

- А. 0,2-0.5 см/цаг
- В. 1 -1.2 см/цаг
- С. 1,2 -1,5 см/цаг
- Д. 1,5 - 2.0см/цаг
- Е. 2.0-2.5 см/цаг

/120./ Төрөлтийн II үеийг хэзээнээс эхэлсэн гэж үзэх вэ?

- А. Ургийн түрүүлсэн хэсэг аарцагт бүрэн суух
- В. Дүлэлт эхлэх
- С. Ургийн толгой дотор эргэх
- Д. Умайн амсар бүрэн нээгдэхэд
- Е. Умайн амсар 5 см нээгдэхэд

/121./ Төрөлтийн үйл ажиллагаа сайн байгааг илтгэх шинжийг нэрлэнэ үү

- А. Умайн базлалт 10 хоромд 1-2 удаа базлалт 25 сек үргэлжилж байвал
- В. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 20-25 сек үргэлжилж байвал
- С. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 40-60 сек үргэлжилж байвал
- Д. Умайн базлалт 10 хоромд 4 удаа 80- секундээс илүү үргэлжилж байвал
- Е. Умайн базлалт 10 хоромд 5-6 удаа 60-80 сек үргэлжилж байвал

/122./ Жирэмсний 6 долоо хоногтойгоос эхлэн эхийн цусны эзэлхүүн нэмэгдэж эхлэх бөгөөд ямар хугацаанд хамгийн дээд хэмжээнд хүрэх вэ?

- А. 20-24 долоо хоног
- В. 25-29 долоо хоног
- С. 30-34 долоо хоног
- Д. 35-37 долоо хоног
- Е. Төрөх дөхөөд ирэхэд

/123./ Цэлмэнгийн биопсийн шинжилгээ гэж юу вэ?

- А. Ургийн шингэнд AFP үзэх
- В. Ургийн ихэснээс авч шинжлэх

- C. Ургийг дурандах шинжлэх
 - D. Ургийг хэт авиагаар шинжлэх
 - E. Ургийн арьснаас эд авч шинжлэх
- /124./ Төрөлтийн далд үед дараах шинж хамаарна:
- A. 10 хоромд 1-2 удаа базлана
 - B. Базлалт жигд биш
 - C. Базлалт 40-60 сек үргэлжилнэ
 - D. Умайн хүзүү 4-5 см нээгдсэн
 - E. Умайн хүзүүний нээгдэх хурд 1,5 см/ цаг болно
- /125./ Ихэс нягт бэхлэгдэнэ гэдэг нь:
- A. Ихэс умайн салстын үйл ажиллагааны давхаргад бэхлэгдэх
 - B. Суурийн давхаргад бэхлэгдэх
 - C. Умайн булчинд хүрч бэхлэгдэх
 - D. Булчингийн гүнд бэхлэгдэх
 - E. Гялтан давхаргад бэхлэгдэх
- /126./ Умайн хүзүүний салиа 8-10 см сунаж байвал БЮМ-ний аль үетэй тохирох вэ?
- A. 1-5 дахь өдөр
 - B. 6-10 дахь өдөр
 - C. 12-14 дахь өдөр
 - D. 16-20 дахь өдөр
 - E. 22-24 дахь өдөр
- /127./ Амнионтестээр үтрээний рН хэд байхад ураг орчмын шингэн гарсан гэж үзэх вэ?
- A. 4-4,5
 - B. 4,5-5,0
 - C. 5,0-5,5
 - D. 5,5-6,0
 - E. 6,5-7,5
- /128./ Ургийн толгойн ямар тавилтын үед төрөх замаар төрөх боломжгүй вэ?
- A. Толгой оройгоор түрүүлэх
 - B. Өврийн тэнхэлгийн бус тавилт
 - C. Урд хэлбийлттэй нүүр түрүүлэлт
 - D. Толгой духаараа түрүүлэх
 - E. Арын янзтай дагз түрүүлэлт
- /129./ Индекс Соловьевын мөн чанар юу вэ?
- A. Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үзнэ
 - B. Ясны зузаан, нимгэн байдлыг тодорхойлно
 - C. Жирэмсний хугацааг тодорхойлох
 - D. Ургийн хөдөлгөөнийг тогтоох арга
 - E. Ургийн зүрхний цохилтыг чагнах арга
- /130./ Умайн гадуурх жирэмсний эмчилгээд хамааралгүйг нэрлэнэ үү
- A. Сальпингостоми
 - B. Сальпингоэктоми
 - C. Хэсэгчлэн тасалж нийлүүлж залгах
 - D. Метотрексат
 - E. Дефундаци
- /131./ Умай- ихсийн дутмагшил үүсэхэд аль нь хамааралгүй вэ?
- A. Ихэс хавагнах
 - B. Чихрийн шижин
 - C. Хүй унжих
 - D. Илүү тээлт
 - E. Ургийн хөгжил баригдах
- /132./ Тэмбүүгийн үед ихсэнд гарах өөрчлөлтийг тэмдэглэнэ үү?
- A. Ихэс хавагнаж, эндо, мезо, периваскулит үүссэн байна.
 - B. Ихэс хатингаршина
 - C. Ихэст өөрчлөлт гарахгүй

D. Ихэс зөөлөрч, улбайна

E. Ихэс шохойжино

/133./ Төрсний дараах эрт үед дундчаар хэдэн мл цус алдах вэ?

A. 300 мл

B. 200 мл

C. 400 мл

D. 500 мл

E. 600 мл

/134./ Хламидийн халдварыг эмчлэхэд үр дүн сайтай эм нь:

A. Пенициллины бүлгийн антибиотикүүд

B. Тетрациклины бүлгийн антибиотикүүд

C. Сульфаниламидын эмүүд

D. Нитрафураны эмүүд

E. Циклоспорины бүлгийн антибиотик

/135./ Улаануудын мирүсийн халдвараа үүдэлтэй ургийн гаж хөгжилд хамааралгүй нэрлэнэ үү

A. Катаракт

B. Артериальний проток хаагдахгүй байх

C. Араг яс булчингийн гаж хөгжил

D. Дүлий

E. Дэлүү томрох

/136./ Хойтхи салахгүй 30 хором болсон, цус алдалтгүй бол ямар тусламж үзүүлэх вэ?

A. Дахин 30 хором ажиглана

B. Ихсийг Альфелдийн аргаар гаргана

C. Умайн агшаах бэлдмэл хэрэглэнэ

D. Умайн хөндийг багажаар хусаж цэвэрлэнэ

E. Ихэс гардаж гаргана

/137./ 4000,0-аас дээш том жинтэй хүүхэд төрүүлдэг өгүүлэлтэй жирэмсэн эмэгтэйд глюкоз задлах байдлыг тодруулах сорил хийхэд цусны сахар өлөн үед 120 мг%, 1 цагийн дараа 180 мг% байв.

A. Сорил хэвийн

B. Чихрийн шижин илэрсэн

C. Сорил өөрчлөлттэй

D. Сорилыг давтан хийх

E. Сорил өөрчлөлтгүй

/138./ Энтероцеле гэдэг нь:

A. Умай унжих

B. Гэдэсний хэсэг унжих

C. Давсаг унжих

D. Үтрээний арын хана унжих

E. Үтрээний урд хана унжих

/139./ Ураг бөгсөөр түрүүлсэн үед толгой чөлөөлөх аргыг нэрлэнэ үү?

A. Ловсетийн арга

B. Пинардын арга

C. Морисо-УмайлТайтын арга

D. Цавъяановын 1-арга

E. дээр Цавъяановын 2-арга

/140./ Жирэмсэн үед эмэгтэйн умдагны үений хоорондох зай хэд см-ээс дээш өргөсөхийг эмгэг гэж үзэх вэ?

A. 0,1 – 0,3 см

B. 0,4 – 0,6 см

C. 0,7 – 0,9 см

D. 1,0 – 1,2 см

E. Хэвийн үед умдагны зай өргөсөх ёсгүй

/141./ Үргүйдэлтэй гэр бүлийг шинжлэхэд хамгийн эхэнд ямар шинжилгээг санал болгох вэ?

- A. Гистеросальпингографи
 - B. Үрийн шингэний шинжилгээ
 - C. Умайн салст бүрхэвчийн биопси
 - D. Үтрээний наацанд эсийн шинжилгээ хийх
 - E. Суурин температурыг үзэх
- /142./ Умайн үйл ажиллагааны цус алдатын шалтгаан:
- A. Умайн хоргүй хавдар
 - B. Умайн салстын карцинома
 - C. Умайн салстын ургацаг
 - D. Умайн салстын гэмжэл
 - E. Бөөрний дээд булчирхайн хэт зузаарал
- /143./ Умайн үйл ажиллагааны цус алдалтын учир эмчлүүлсэн 46 настай эмэгтэйд дахин цус алдалтаас сэргийлж ямар эмчилгээг сонгох вэ?
- A. БЮМ-ийн 5-25 дахь хоногт ригеводон 3 сар уулгана
 - B. БЮМ-ийн 5-25 дахь хоногт Норколут 5 мг-аар 3 сар уулгана
 - C. БЮМ-ийн үед микротунтай дааврын хавсарсан эм 3 сар уулгана.
 - D. Өндөр тунтай ДХЭ 3 сар хэрэглэнэ.
 - E. БЮМ-ийн 5-25 дахь хоногт премарин уулгана.
- /144./ Аль нь одоо дутуу төрөх эрсдэл байгааг илэрхийлэх вэ?
- A. Ургийн фибронектин илэрсэн
 - B. Өмнө нь дутуу төрж байсан өгүүлэмжтэй
 - C. Умайн хүзүүний урт <25 мм байх
 - D. Ахимаг насны тулгар төрөгч
 - E. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй байх
- /145./ Умайн гуурсан хоолойн битүүрлийг оношлох алтан стандарт аргыг нэрлэнэ үү
- A. Гистеросальпингографи
 - B. Пневмопельвиографи
 - C. Кульдоскопи
 - D. Лапароскопи
 - E. Пертубаци
- /146./ Умайн хамааралтай БЮМ –гүйдэлд хамаарах нь:
- A. Пролакины хэмжээ 100нг/л ихсэх
 - B. ФСГ түвшин нэмэгдсэн
 - C. ЛД буурсан
 - D. Прогестероны сорил сөрөг бол
 - E. Умайн хэмжээ томорсон
- /147./ Ургийн зүрхний цохилт түргэсгэх шалтгаанд хамааралгүйг нэрлэнэ үү
- A. Цус багадалт
 - B. Бамбайн хордлого
 - C. Ургийн бүтэлт
 - D. β блокатор хэргэлэхэд
 - E. Эх халуунтай байхад
- /148./ “Дунших” шинжид хамаарахыг нэрлэнэ үү:
- A. Ууц нуруугаар болон хэвлийн доогуур өвдөнө
 - B. Биеийн жин долоо хоногт 800 гр нэмэгдэх
 - C. Үтрээнээс цуслаг салиа гарах
 - D. Умай жигд базалж эхлэх
 - E. Хөхнөөс уураг гоожих
- /149./ Эхийн аарцгийн хэмжээ 28-28-30-18-11 байна, Аарцгийн хэлбэрийг тодорхойлно уу?
- A. Жигд уйтарсан аарцаг
 - B. Хөндлөн уйтарсан аарцаг
 - C. Жигд уйтарсан хавтгай аарцаг
 - D. Энгийн хавтгай аарцаг
 - E. Сульдаагийн үеийн хавтгай аарцаг
- /150./ Ихэс түрүүлэлтийн үед илрэх эмнэл зүйн гол шинжийг нэрлэнэ үү:

- A. Умай чангарч, хоёр тал жигд биш, эмзэглэлтэй
 - B. Удаан хугацаагаар их хэмжээтэй цус алдах
 - C. УЗЦ байхгүй болох
 - D. Умай чангаралгүй, улаан ягаан цус гарах
 - E. Дотор муухай оргиж бөөлжих
- /151./ Ураг хөндлөн байрласан үед ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?
- A. Эхийн хүйнээс доор
 - B. Эхийн хүйнээс дээр
 - C. Эхийн хүйн баруун эсвэл зүүн талд
 - D. Эхийн аюулхай орчим
 - E. Умдаг ясны орчим
- /152./ Ж.15 нэстай БЮМ ирээгүй. Бэлгийн хоёрдогч шинж ямар дэс дараалалаар хөгжлөг болохыг нэрлэнэ үү
- A. Үсжилт, өсөлт хурдсах, хөх томрох, БЮМ ирэх
 - B. Өсөлт хурдсах, үсжилт, хөх томрох, БЮМ ирэх
 - C. Өсөлт хурдсах, хөх томрох, үсжих, БЮМ ирэх
 - D. Хөх томрох, үсжилт, өсөлт хурдсах, БЮМ ирэх
 - E. Хөх томрох, БЮМ ирэх, өсөлт хурдсах, үсжилт
- /153./ Жирэмсний эхний 3 сарыг ямар үе гэж нэрлэх вэ?
- A. Органогенезийн үе
 - B. Үр хөврөлийн үе
 - C. Ихэсжих үе
 - D. Ургийн үе
 - E. Умайд бэхлэгдэх үе
- /154./ Дунших үед ямар эмчилгээг хийх вэ?
- A. Өвчин намдаах, агчилт тавиулах эмчилгээ
 - B. Төрөх хүчийг дэмжих
 - C. Ураг орчмын шингэнийг хагалах
 - D. Умайн хүзүүг төрөлтөд бэлтгэх
 - E. Далд үеийн удаашрал гэж үзнэ
- /155./ Кефалогематом гэдэг нь:
- A. Зөөлөн эдийн хаван
 - B. Арьсан дор цус хурах
 - C. Ясны хальсанд цус хурах
 - D. Субарахноидальное цус харвалт
 - E. Тархины ховдолд цус харвах
- /156./ Жирэмсэн үед эклампси үүсвэл ямар арга хэмжээ авах вэ?
- A. Эрчимт эмчилгээний тасагт бүрдмэл эрчимт эмчилгээ хийж хянана
 - B. Эрчимт эмчилгээтэй хамт төрөлтийг яаралтай сэдээнэ
 - C. Умайн хүзүү төрөлтөнд бэлтгэгдсэн бол амниотоми хийнэ
 - D. Яаралтай кесар хагалгаа хийнэ
 - E. Таталт тавигдсанбол цааш жирэмслэлтийг үргэлжлүүлэх боломжтой байна
- /157./ Аль нь өндгөвчийн хучуур эдийн гаралтай хавдарт хамаарахыг нэрлэнэ үү
- A. Хуурамч муцинт хавдар
 - B. Десгерминома
 - C. Тератома
 - D. Мөхлөгт эсийн хавдар
 - E. Дермоид
- /158./ Хавчуур тавих нөхцөлд хамаарахгүйг нэрлэнэ үү?
- A. Ураг амьд
 - B. Тулгар төрөгч
 - C. Умайн хүзүү бүрэн нээгдсэн
 - D. Ургийн толгой аарцгийн 0/5 тавигдсан
 - E. Нөхцөл шаардлагагүй
- /159./ 1800гр жинтэй төрсөн нярайг хэддүгээр зэргийн дутуу гэж үзэх вэ?

- A. I зэрэг
- B. II зэрэг
- C. III зэрэг
- D. IV зэрэг
- E. V зэрэг

/160./ Умайн агшилт суларч цус алдахад нөлөөлөх шалтгааныг нэрлэнэ үү?

- A. Өгзөг төрүүлэлт
- B. Ургийн архаг бүтэлт
- C. Ихэр жирэмсэн
- D. Жирэмсний эрт түеийн хордлого
- E. Д амин дэмийн дутагдал

/161./ Энтероцеле гэдэг нь:

- A. Умай унжих
- B. Гэдэсний хэсэг унжих
- C. Давсаг унжих
- D. Үтрээний арын хана унжих
- E. Үтрээний урд хана унжих

/162./ Төрөөгүй эмэгтэйчүүдэд ерөндөг тавьсан нөхцөлд ямар хүндрэл илүүтэй тохиолдож болох вэ?

- A. Зулбалт
- B. Аарцгийн венийн бөглөрөлт үрэвсэл
- C. Дотор бэлэг эрхтэний үрэвсэл өвчин
- D. Умайн хүзүүний дутмагшил үүснэ
- E. Хөлийн венийн бүдүүрэл

/163./ Жирэмслэлт төрөлтийн үед бөөр шээсний замын хурц халдвар үүсгэхэд хамааралгүйг нэрлэнэ үү.

- A. Умай томорч шээлгүүрийг дарснаас
- B. Шээлгүүрийн гүрвэлзэх хөдөлгөөн нэмэгдсэнээс
- C. Шинж тэмдэггүй бактериури
- D. Эпидураль мэдээ алдуулалтын дараа давсангы хүчдэл буурснаас
- E. Төрсний дараа давсанд катетер тавснаас

/164./ Өндгөвчийн хучуур эдийн хоргүй хавдарт аль нь хамаарахыг нэрлэнэ үү

- A. Эндометриома
- B. Шар биеийн уйланхай
- C. Муцинт кистома
- D. Дермояд уйланхай
- E. Фолликулын уйланхай

/165./ Ургийн буруу байрлал үүсэх шалтгааныг нэрлэнэ үү?

- A. Тулгар жирэмсэн
- B. Жирэмсний хордлого
- C. Төрөх хүчний сулрал
- D. Ихэс түрүүлэлт
- E. Төрөх үеийн цус алдалт

/166./ Төрөх үед умайн дотоод даралт хэдэн МУБӨ байх вэ?

- A. 20-30 мм. МУБӨ
- B. 35-50 мм. МУБӨ
- C. 50-70 мм. МУБӨ
- D. 80-100 мм. МУБӨ
